



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар Б/146

Хэрлэн сум

**Н.Түвшинжаргалыг туршилтын  
хугацаагаар ажилд томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2024 оны “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 82 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн жижүүрийн албан тушаалд Нэргүйн Түвшинжаргалыг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн туршилтын 3 сарын хугацаагаар ажилд томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Н.Баярсайхан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн дарга
Гишүүд:	С.Сарангоо	Аймгийн Засаг даргын Тамгын газрын аж ахуйн тасгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, зохион байгуулалт хариуцсан ажилтан
	Т.Баяртуяа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав

3. Н.Түвшинжаргалын сарын үндсэн цалинг ТҮ-1 зэрэглэлээр тогтоон, 900,000 (есөн зуун мянга) төгрөгөөр тооцож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2

2.

хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Н.Түвшинжаргалд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА